



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/269

Булган сум

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн хэмжээнд цөлжилт, газрын доройтол бэлчээрийн талхлагдал зэрэгт үнэлгээ хийж менежментийн төлөвлөгөө боловсруулах” ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны
газрын дарга)

Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
дарга)

С.Алтанзул (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Б.Март (Байгаль орчны газрын Газар, газрын
хэвлий түүний баялгийн ашиглалт хамгаалалт,
нөхөн сэргээлт, газар зүйн мэдээллийн систем
хариуцсан мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

М.Алтанцэцэг (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Будцэцэг (Худалдан авах ажиллагааны газрын
мэргэжилтэн)

6326010377

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Г.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

